

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/87/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn
Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг
Утас: 70432545

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ЗДТГ	<i>Засаг даргын дамгын газар</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
БҮТЭЗ	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	7
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	12
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	13
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	13
3.АУДИТЫН ТАЙЛАН	15
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	20
.....	Error! Bookmark not defined.
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	21
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	22

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав бл, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.НОМИНЧИМЭГ ТАНАА

2021.02.25 № 4/152
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хүүхэд нэг бүрийн хамгаалал, залуучуудын оролцоог дэмжин, өрх гэр бүлийн боловсрол, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсвийн хэмнэлтээс шатахууны талон худалдан авч нөөцөлсөн, Аймгийн онцгой комиссын шийдвэрээр тендер зарлаагүй хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны тавилга эд хогшил худалдаж авсан, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээллээгүй зэрэг зөрчлүүд "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

021020678

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,989,387.00	54,988,203.50
33	АВЛАГА	1,303,646.00	404,596.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,303,646.00	83,246.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	320,700.00
335	Бусад авлага	-	650.50
3351	Байгууллагаас авах авлага	-	650.50
35	БАРАА МАТЕРИАЛ	31,685,741.00	54,583,607.00
354	Хангамжийн материал	31,685,741.00	54,583,607.00
35410	Бичиг хэргийн материал	25,000.00	-
35420	Аж ахуйн материал	31,660,741.00	51,687,857.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,895,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,404,290,246.70	1,406,816,570.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,404,290,246.70	1,406,816,570.10
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,322,227,642.34	1,324,644,965.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,150,280.00	1,147,150,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,119,171.36)	(38,238,342.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,958,333.34)	(4,308,333.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,075,387.00	130,509,187.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,488,467.60)	(95,998,419.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,248,349.00	169,134,309.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(138,340,451.52)	(142,013,765.24)

39214	Бусад үндсэн хөрөнгө	178,367,170.00	178,367,170.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,973,119.84)	(58,223,119.80)
39217	Ном	14,766,000.00	14,766,000.00
393	Биет бус хөрөнгө	82,062,604.36	82,171,604.28
39301	Програм хангамж	6,713,000.00	7,093,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,554,995.64)	(5,825,995.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,904,600.00	80,904,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,437,279,633.70</u>	<u>1,461,804,773.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,038,284.00</u>	<u>3,564,001.84</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
		1,038,284.00	3,564,001.84
413	Өглөг	1,038,284.00	3,564,001.84
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,038,284.00	1,156,963.84
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,546,038.00
4136	Бусад өглөг	-	861,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	861,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,436,241,349.70</u>	<u>1,458,240,771.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,436,241,349.70	1,458,240,771.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,301,682,672.00	1,301,682,672.00
512	Хуримтлагдсан үр дүн	(663,711,908.39)	(641,712,486.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(663,711,908.39)	(664,932,308.39)
51220	Тайлант үеийн үр дүн	-	23,219,822.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,270,586.09	798,270,586.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,437,279,633.70</u>	<u>1,461,804,773.60</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	534,443,239.00	731,714,223.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,494,594.00	36,770,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,494,594.00	12,711,000.00
120003	Торгуулийн орлого	267,094.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,227,500.00	12,711,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,907,500.00	5,865,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	320,000.00	6,846,000.00
122	Тусламжийн орлого	-	24,059,960.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	24,059,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	525,948,645.00	694,943,263.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	293,058,800.00	512,484,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,058,800.00	512,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,996,903.00	38,819,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,810,403.00	23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,449,000.00	14,654,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	247,500.00	1,164,200.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	137,829,100.00	143,609,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	137,829,100.00	143,609,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	63,842.00	30,563.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	63,842.00	30,563.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	571,277,316.29	708,494,400.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,277,316.29	708,494,400.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,210,703.69	616,572,259.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,873,931.00	252,973,400.00
210101	Үндсэн цалин	128,170,931.00	218,461,098.00
210102	Нэмэгдэл	37,703,000.00	34,512,302.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,182,553.00	32,352,452.42
210201	Тэтгэврийн даатгал	14,220,265.00	22,135,990.53
210202	Тэтгэмжийн даатгал	1,338,378.00	2,564,081.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,672,972.00	2,041,185.54
210204	Ажилгүйдлийн даатгал	334,594.00	508,230.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,616,344.00	5,102,963.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,707,116.00	127,155,471.00
210301	Гэрэл, цахилгаан	2,953,107.00	3,483,538.00
210302	Түлш, халаалт	116,871,683.00	120,361,133.00
210303	Цэвэр, бохир ус	2,882,326.00	3,310,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,489,383.50	109,194,139.10
210401	Бичиг хэрэг	169,500.00	4,640,520.00
210402	Тээвэр, шатахуун	351,120.00	3,548,039.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,763.50	1,586,251.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	445,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	98,974,328.00
2105	Нормативт зардал	-	168,600.00
210502	Хоол, хүнс	-	168,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,059,402.90	-

210604	Урсгал засвар	27,059,402.90	-
2107	Томилолт, зочны зардал	515,100.00	878,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	515,100.00	878,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,904,238.00	40,191,323.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,701,238.00	39,616,816.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	52,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	626,500.00	86,007.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,478,979.29	53,658,873.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,111,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,276,490.00	405,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,202,489.29	38,173,436.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15,920,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,922,366.50	75,271,078.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,922,366.50	75,271,078.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,180,404.10	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,180,404.10	
3	ҮЙЛ АЖИЛЛАГА ААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(36,834,077.29)	23,219,822.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(36,834,077.29)	23,219,822.06

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	533,856,145.00	700,808,263.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,907,500.00	5,865,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,907,500.00	5,865,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,907,500.00	5,865,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,907,500.00	5,865,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	525,948,645.00	694,943,263.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	293,058,800.00	512,484,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,058,800.00	512,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,996,903.00	38,819,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,810,403.00	23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,449,000.00	14,654,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	247,500.00	1,164,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	137,829,100.00	143,609,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	137,829,100.00	143,609,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	63,842.00	30,563.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	63,842.00	30,563.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	533,856,145.00	700,808,263.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,856,145.00	700,808,263.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,789,532.40	608,365,421.72

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,251,020.00	193,871,109.00
210101	Үндсэн цалин	137,548,020.00	129,657,020.55
210102	Нэмэгдэл	37,703,000.00	64,214,088.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,077,800.00	26,209,504.00
210201	Тэтгэврийн даатгал	14,332,900.00	18,451,704.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,686,200.00	1,939,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,000.00	1,551,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	337,200.00	387,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,372,500.00	3,879,000.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,947,996.00	125,845,633.00
210301	Гэрэл, цахилгаан	2,953,107.00	2,834,500.00
210302	Түлш, халаалт	116,871,683.00	120,361,133.00
210303	Цэвэр, бохир ус	3,123,206.00	2,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,689,583.50	6,374,100.00
210401	Бичиг хэрэг	524,500.00	2,471,600.00
210402	Тээвэр, шатахуун	351,120.00	1,798,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,813,963.50	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,104,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,419,602.90	18,150,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,575,000.00	
210604	Урсгал засвар	26,844,602.90	18,150,000.00
2107	Томилолт, зочны зардал	515,100.00	-
210702	Дотоод албан томилолт	515,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,886,760.00	212,036,238.72

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,542,960.00	210,949,739.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	767,300.00	499,999.60
210807	Газрын төлбөр	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,001,670.00	25,878,837.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,001,670.00	9,659,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,066,612.60	92,442,841.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	963,842.00	16,851,063.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	63,842.00	30,563.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	15,920,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,922,366.50	75,591,778.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,922,366.50	75,591,778.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,180,404.10	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,180,404.10	

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(663,711,908.39)	1,436,241,349.70
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(663,711,908.39)	1,436,241,349.70

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,220,400.00)	(1,220,400.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(664,932,308.39)	1,435,020,949.70
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(641,712,486.33)	1,458,240,771.76

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	663,689,700.00	586,687,521.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	663,689,700.00	586,687,521.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,869,200.00	569,867,021.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,948,300.00	193,948,300.00
210101	Үндсэн цалин	139,087,500.00	129,657,020.55
210102	Нэмэгдэл	54,860,800.00	64,291,279.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,182,900.00	26,209,504.00
210201	Тэтгэврийн даатгал	18,425,100.00	18,425,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,939,500.00	1,939,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,551,600.00	1,551,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	387,700.00	387,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,879,000.00	3,905,604.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,533,800.00	125,845,633.00
210301	Гэрэл, цахилгаан	3,634,500.00	2,834,500.00
210302	Түлш, халаалт	136,588,300.00	120,361,133.00
210303	Цэвэр, бохир ус	3,311,000.00	2,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,420,000.00	6,374,100.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,471,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,798,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,120,000.00	1,104,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,700.00	30,000.00
210604	Урсгал засвар	75,700.00	30,000.00
2107	Томилолт, зочны зардал	719,800.00	-
210702	Дотоод албан томилолт	719,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	266,317,200.00	207,800,084.72

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,690,700.00	206,713,585.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	499,999.60
210807	Газрын төлбөр	550,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,671,500.00	9,659,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,671,500.00	9,659,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,820,500.00	16,820,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,820,500.00	16,820,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,920,500.00	15,920,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	663,689,700.00	586,687,521.72
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	513,230,200.00	437,213,021.72
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	513,230,200.00	437,213,021.72
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,609,500.00	143,609,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	143,609,500.00	143,609,500.00
1E+05	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,850,000.00	5,865,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,850,000.00	5,865,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,996,902.90	38,819,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,996,902.90	22,559,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,996,902.90	22,559,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,727,902.90	18,120,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,575,000.00	
210604	Урсгал засвар	29,152,902.90	18,120,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,118,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,118,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,269,000.00	320,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,269,000.00	320,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,259,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,259,800.00
222001	Тоног төхөөрөмж		8,869,800.00
223001	Бусад хөрөнгө		7,390,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94,996,903.00	38,819,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,996,903.00	38,819,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,810,403.00	23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,449,000.00	14,654,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	247,500.00	1,164,200.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Ц.Номинчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн, төсвийн зарцуулалтад хяналт тавих, шатахууны зарцуулалт болон И баримттай бараа материал худалдан авч хэвших, шилэн дансны хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь “хүүхэд нэг бүрийн хамгааллыг сайжруулж, залуучуудын оролцоог дэмжин, өрх гэр бүлийн боловсрол, хариуцлагыг нэмэгдүүлэх”, “ хүүхэд төвтэй, гэр бүлд суурилсан хүүхдийн эрх хамгаалал, хөгжил оролцоог төрийн бодлого хуулийн хүрээнд ханган ажиллахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

2009.04.12-ны өдрийн 01 дугаар ИТХ-ын тогтоолоор Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг “Төрийн бодлого хэрэгжүүлэгч агентлагийн чиг үүрэгтэй ажиллах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-нд батлагдсан Журам батлах тухай 382 дугаар тогтоолыг 2020 оны 01-р сарын 1-нээс мөрджээ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын алба байгуулаагүй, дотоод аудитын нэгжгүй, хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно. Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн баримтанд дотоод хяналт хийсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 533875,7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5338,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 731714.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7317.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24525.1 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	1.303.6	404.6	-899.0
БАРАА МАТЕРИАЛ	31.685.7	54.583.6	22.897.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1.404.290.2	1.406.816.6	2.526.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,437,279,6	1,461,804,8	24,525,1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,038,3	3,564,0	2,525,7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,436,241,3	1,455,240,8	21999,4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,437,279,6	1,461,804,8	24,525,1

Авлага дансны үлдэгдэл 404.6 мянган төгрөг болж буурсан шалтгаан нь тус газрын 2018 оны 1220.4 мянган төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэрээр хүчингүй болсонтой холбоотой буурсан бөгөөд энэ авлага нь санхүүжилтийн авлага учир бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54583,6 мянган төгрөг болж 22897,9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй 6846.0 мянган төгрөгийн бараа материалаар өссөн, мөн ковид 19-тэй холбоотой хүнсний материал, шатахуун нөөцөлсөнтэй холбоотой өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1,404,290.2 мянган төгрөг, оны эцэст 1,406,816,6 мянган төгрөг болж 2526.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Дэлхийн зөн ОУБ-ын оруулалтаар хөрөнгө оруулалтаар 24059,9 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг хандиваар авч, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 16639.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч нийт 40669,8 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр оны эхэнд 1038,3 мянган төгрөг, оны эцэст 3564,0 мянган төгрөг болж 2525,7 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн өмчийн газарт түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлээгүй, төсвийг зөв зохистой зарцуулаагүйгээс тогтмол зардлын өр үүссэн ба өмнөх оны өрийг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,436,241,3 мянган төгрөг, оны эцэст 1,458,240,8 мянган төгрөг болж 21999,4 мянган төгрөгөөр өссөн байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 197270.9 мянган төгрөгөөр буюу 36.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 197271.0 мянган төгрөгийн орлогоос 168994.6 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 28276,4 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 136356,1 мянган төгрөгөөр буюу 23.9 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 98269.4 мянган төгрөг буюу 52,5 хувиар, бараа үйлчилгээний зардал 38086.7 мянган төгрөг буюу 47,5 хувиар дээрх зардлууд өссөн байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, хүүхдийг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, түр хамгаалах байр ашиглалтанд орсонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 656839.7 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 6850.0 мянган төгрөгөөр нийт орлогыг 663689.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 663689.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 663689.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 512484.1 мянган төгрөгийг Улсын төсвөөс, орон нутгийн санхүүжилтээр 143609.5 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны орлого 6850.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 512484.4 мянган төгрөгийн, орон нутгаас 143609.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5865.0 мянган төгрөг нийт 661958.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 586687.5 мянган төгрөгийг зарцуулж 75271.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	410.0
80102	Туслах үйл ажиллагааны зардал	43988.4
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1969.9
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	17733.9
80233	Хүүхэд хамгаалал	11168.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0
	ДҮН	75271.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 38819.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 38819.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 100 мэдээллээс хугацаандаа оруулсан 54 мэдээлэл, 44 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй, санхүүгийн тайлан, нэмэлт дансаар орсон гарсан гүйлгээний талаар огт мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9187.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 63.1 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	0	-	-	-	-	-
Албан шаардлага	1	104914.3	1	104914.3	-	-	100
Зөвлөмж	3	9187.2	1	5794,3	2	3392.9	36.9
Нийт дүн	4	114101.5	2	3744.7	2	3392.9	63.1

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63422.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 55585.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 7109,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгч, 729,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүжилтийн орлогыг 16504,5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, үндсэн хөрөнгийг орлого аваагүй 16259,8 мянган төгрөг, нэмэлт данснаас төвлөрүүлсэн 320,0 мянган төгрөгийг авлагаар тусгасан, Орон нутгийн өмчийн газарт түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлээгүй 861,0 мянган төгрөгийг өглөгөөр тайлагнасан, бараа материалыг 19557,9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, тайлант үеийн үр дүн 861,0 мянган төгрөгөөр зөрүүтэй, 2018 оны авлага 1220,4 мянган төгрөгийг өмнөх үр дүнд Шүүхийн шийдвэрээр залруулсан нийт 55584.6 мянган төгрөгийн алдааг илрүүлж залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 55584,6 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7837.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 729.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7107,9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд хүнсний болон бараа материал хувь хүмүүсээс худалдан авахдаа, гэрээгээр ажилласан хүмүүсээс хувь хүний орлогын албан татвар суутгаж аваагүй, төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой 729.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл энэ хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан татвар төлөгч байна”, 7.1.6.“үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”;8.1.2.хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоос татвар төлнө гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

2. 2020 онд нийт 7107.9 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авсан боловч зарцуулалтын тайлан гаргаагүй, төлбөрийг төлөхдөө бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэх, бусад нотлох баримтгүй ажил гүйлгээ хийгдсэн, жолоочийн тооцооны хуудсыг жолооч нар нь тухайн сард авсан шатахуундаа тааруулан км бичсэн, нягтлан бодогч нь жолоочийн замын хуудсыг хаана хэний зөвшөөрлөөр ажилласныг тулган баталгаажуулж тооцоог сар бүр, бодоогүй, төсвийн үргүй зардал гаргасан нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д “Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 7107.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж:

Аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар тээвэр шатахууны болон бараа үйлчилгээний бусад зардал, хүүхдийн хариу үйлчилгээ үзүүлэх зардлуудын давтан хянах шаардлагатай.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг мэдээлээгүй, нэмэлт дансны орлого, зарлагыг байршуулаагүй байна.

1.2. Эрсдэл: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтыг мөрдөөгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.5.4-д “улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, хүүхдийн хариу үйлчилгээ үзүүлэх байрны тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын нийлүүлэлт, хуримын ордоны засварын ажил хүлээлцсэн акт байхгүй, түлш шатах тослох материал орлого, зарлагын зарцуулалтад дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.

2.2 Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах,

2.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/87/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлсэн	861.0	Залруулга хийх	Дарга , нягтлан бодогч	Ц.Номинчимэг Ц.Отгонхишиг
2	Үндсэн хөрөнгө худалдаж авсан боловч хөрөнгөд орлого аваагүй зөрчил илэрлээ.	16259.8	Залруулга хийх		
3	Түрээсийн орлогын 30 хувийг Орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлээгүй байсныг өглөгөөр тусгуулсан.	861.0	Залруулга хийх		
4	Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 320,7 мянган төгрөгийг буцаан авахаар авлагаар тайлагнасан	320.7	Залруулга хийх		
5	Бараа материалын тайлангийн эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан	19557,9	Залруулга хийх		
6	Урсгал үйл ажиллагааны орлогыг алдаатай тайлагнасан	16504,5	Залруулга хийх		
7	2018 оны авлага болох 1220,4 мянган төгрөгийг Шүүхийн шийдвэрээр өмнөх үр дүнгийн тайланд залруулга хийсэн	1220,4	Залруулга хийх		
8	2020 онд нийт 7107.9 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авсан боловч зарцуулалтын тайлан гаргаагүй, төлбөрийг төлөхдөө бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэх, бусад нотлох баримтгүй ажил гүйлгээ хийгдсэн, жолоочийн тооцооны хуудсыг жолооч нар нь тухайн сард авсан шатахуундаа тааруулан км бичсэн, нягтлан бодогч нь жолоочийн замын хуудсыг хаана	7107.9	Албан шаардлага өгөх		

	хэний зөвшөөрлөөр ажилласныг тулган баталгаажуулж тооцоог сар бүр, бодоогүй, төсвийн үргүй зардал гаргасан нь				
8	Тайлант онд хүнсний болон бараа материал хувь хүмүүсээс худалдан авахдаа, гэрээгээр ажилласан хүмүүсээс хувь хүний орлогын албан татвар суутгаж аваагүй, өглөгөөр бүртгээгүй, хэмнэсэн төсвийн мөнгөөр шатахуун нөөцөлсөн зэрэгтэй холбоотой 3625.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	729,3	Төлбөрийн акт		
9	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг мэдээлээгүй, нэмэлт дансны орлого, зарлагыг байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгөх		
10	Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, түлш шатах тослох материал орлого, зарлагын зарцуулалтад дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		63422,6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР